

ГУАН ДУН МУЖИЙН ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

ШИНЭ ХЭЛБЭРИЙН КОРОНА ВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ НЬ

- Шинэ хэлбэрийн корона вирус гэж юу вэ?
- Шинэ хэлбэрийн корона вирус халдварлалын шинж тэмдэг нь юу вэ?
- Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвараас хэрхэн сэргийлэх вэ?

ГУАН ДУН МУЖИЙН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНИК МЭРГЭЖЛИЙН ХЭВЛЭЛИЙН ХОРОО
2020 ОН

ӨМНӨХ ҮГ

2020 оны 1 сард Хү бэй мужийн У хань хот зэрэг газарт шинэ хэлбэрийн титэмлэг (корона) вирусийн халдварлалаас үүссэн уушгины хатгаа дэлгэрсэн явдлыг Намын төв хороо ба Төрийн зөвлөл онцгойлон анхааралдаа аваад байна. БНХАУ-ын Коммунист намын дарга, улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Ши жинь Пин хэлэхдээ: "Шат шатны намын хороо, Засгийн удирдлагын ордны болон хамаарал бүхий байгууллагууд ард нийтийн амь нас, эрүүл мэндийг тэргүүн байранд тавьж, нарийн төлөвлөгөө гаргаж, бүх талын хүчийг дайчлан, өвчнөөс сэргийлэн хязгаарлах арга хэмжээ авч, вирусээр халдварлагсдыг шалган илрүүлж, системтэй эмчилгээ хийх хэрэгтэй. Өвчний талаар нэгдсэн зөв ойлголт өгөх, мэргэжлийн үүднээс тайлбарлан ойлгуулах, нийгмийн тогтвортой байдалд туйлаас анхаарах хэрэгтэй" гэжээ. Үүнээс үндэслэн Гуан дун мужийн хэвлэлийн бүлэглэл, "Нань фаны хэвлэл мэдээлэл" ХХК-д харьяалагдах Гуан дун мужийн Шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо болон Гуан дун мужийн Халдварт өвчин судлалын төв хамтран нийгмийн хариуцлагын хүрээнд илүү цагаар ажиллан "Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас сэргийлэх нь" ном хэвлүүлэн тархааж байна.

Тус номд ард нийтийн сэтгэлийг түгшээж буй корона вирусийн талаарх энгийн ойлголт, илрэлийн шинж тэмдэг, хэрхэн урьдчилан сэргийлэх, зарим буруу ойлголт гэсэн үндсэн дөрвөн агуулгыг багтаасан бөгөөд асуулт хариултын хэлбэрээр энэ өвчний үүсэл, хувиралт, шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүсэх шинж тэмдэг, халдварлах арга зам, амархан халдварлаж болзошгүй хүмүүс, мэргэжлийн байгууллагаас анхааруулж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг энгийн ойлгомжтой тайлбарлан таниулж, уншигчдад зөв ойлголт өгөхийг зорьсон болно. Мөн ард олны дунд шинэ хэлбэрийн корона вирусийн талаарх буруу ойлголт, хувийн таамаглалаас үүссэн эмх замбараагүй байдлыг арилгахад тус дөхөм болохын зэрэгцээ үнэн зөв ойлголттой болгоход чиглэсэн билээ.

Тус ном нь агуулгын хувьд системтэй, зураг тайлбар хосолсон хэлбэрээр шинэ хэлбэрийн корона вирусийн талаар аль болохоор бүрэн гүйцэд, шинжлэх ухаанч байр сууринаас энгийн ойлгомжтой тайлбарласан тул ард нийтийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зохих тус нэмрээ үзүүлнэ хэмээн найдаж байна.

ГАРЧИГ

Нэг. ЭНГИЙН ОЙЛГОЛТ

1. Корона вирус гэж юу вэ?
2. Шинэ хэлбэрийн корона вирус гэж юу вэ?
3. Шинэ хэлбэрийн корона вирус нь SARS, MERS-ээс ялгаатай юу?
4. Ямар хэлбэрийн корона вирус хүнд халдварладаг вэ?
5. Шинэ хэлбэрийн корона вирус хүнээс хүнд халдварладаг уу?
6. Шинэ хэлбэрийн корона вирус хэрхэн тархан дэлгэрдэг вэ?
7. Шинэ хэлбэрийн корона вирусийн тархалт ноцтой юу?
8. Шинэ хэлбэрийн корона вирусийн эсрэг вакцин бий юу?
9. Шинэ хэлбэрийн корона вирус халдварлахаас сэргийлэх эм бий юу?
10. Шинэ хэлбэрийн корона вирусээр халдварласан уушгины үрэвслийг эмчилж чадах уу?
11. Ойрын хавьтагч гэж хэнийг хэлж байна вэ?
12. Халдварт өвчин судлалын газраас ойрын хавьтагчаар тодорхойлсон тохиолдолд ямар арга хэмжээ авбал зохих вэ?
13. Ойрын хавьтагчийг яагаад 14 хоног тусгаарлан ажигладаг вэ?
14. Халдварт өвчний хэдэн төрөл байдаг вэ? Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвараас үүссэн уушгины үрэвсэл аль төрөлд багтах вэ?
15. Шинэ хэлбэрийн корона вирусээр халдварласан хүн бүр уушгины үрэвсэлтэй болох уу?
16. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар авсан өвчтөн эмнэлэгт очиж үзүүлэхдээ ямар арга хэмжээ авбал зохих вэ?

Хоёр. ӨВЧНИЙ ИЛРЭЛ, ШИНЖ ТЭМДЭГ

1. Корона вирусийн халдвар авсан бол ямар шинж тэмдэг илрэх вэ?
2. Халуурах, ядрах, хий ханиалгах шинж тэмдэг илэрсэн бол шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар авсан гэж ойлгож болох уу?
3. Ямар шинж тэмдэг илэрвэл эмчид хандах шаардлагатай вэ?
4. Халуурах, ханиах шинж тэмдэгтэй өвчтөнд эмнэлгийн байгууллагаас ямар эмчилгээ хийж байна вэ? Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвслийг хэрхэн оношилж байгаа вэ?
5. Танд шинэ хэлбэрийн корона вирус халдварласан байж болзошгүй шинж тэмдэг илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?

6. Таны ойр хавийн хүмүүст шинэ хэлбэрийн корона вирус халдварласан байж болзошгүй шинж тэмдэг илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?
7. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалын шинж нь SARS, томуу төст өвчин, ханиаднаас ялгаатай юу?
8. Ямар хүмүүст шинэ хэлбэрийн корона вирус амархан халдварлаж байна вэ?
9. Ямар хүмүүст шинэ хэлбэрийн корона вирус халдварлавал амархан хүндэрдэг вэ?

Гурав. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Шинэ хэлбэрийн корона вирус халдварлахаас хэрхэн сэргийлэх вэ?
2. Ойрын хугацаанд халдварт өвчин дэлгэрсэн газар орноор зорчигсад ямар арга хэмжээ авбал зохих вэ?
3. Ханиах, найтаах үедээ яах ёстой вэ?
4. Шинэ хэлбэрийн корона вирусээс сэргийлэхийн тулд хэрхэн ариутгал цэвэрлэгээ хийх вэ?
5. Амны хаалтыг хэрхэн сонгох вэ?
6. Амны хаалтыг хэрхэн зөв зүүх вэ?
7. Гараа хэрхэн зөв угаах вэ?
8. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас сэргийлэхэд идээ ундандаа хэрхэн анхаарах вэ?
9. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас гэр орондоо хэрхэн сэргийлэх вэ?
10. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас гадагш гарахдаа хэрхэн сэргийлэх вэ?
11. Ахмад настан, бага насны хүүхэд шинэ хэлбэрийн корона вирусийн халдвараас хэрхэн сэргийлэх вэ?
12. Амьтны дэлгүүр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах дэлгүүрээр үйлчлүүлэхдээ шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас хэрхэн сэргийлж явах вэ?
13. Найз нөхөд, хамт олны уулзалт цуглаанд очихдоо шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас хэрхэн сэргийлэх вэ?
14. Олон нийтийг хамарсан уулзалт цуглаанд очихдоо шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас хэрхэн сэргийлэх вэ?

Дөрөв. БУРУУ ОЙЛГОЛТ

1. Өрөө тасалгаагаа хоолны цуугаар ариутгавал шинэ хэлбэрийн корона вирусийг устгаж чадах уу?
2. Вирусны эсрэг phosphoric acid, oseltamivir эм уувал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?
3. Антибиотек уувал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?
4. Витамин С уувал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?
5. Амны хаалтыг давхарлан зүүвэл шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?
6. Ханиад, томуу томуу төст өвчний вирусээс сэргийлж ханиад томууны вакцин тариулдаг. Энэ вакциныг тариулбал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж, вирусээр халдварласан ч гэсэн өвчин хүндрэхгүй байж чадах уу?

ЭНГИЙН ОЙЛГОЛТ.

1. Корона вирус /титэмлэг вирус/ гэж юу вэ?

Корона вирус гэдэг нь байгаль дээр тархан оршиж байгаа вирусний нэг төрөл юм. Микросопоор томруулан харахад титэм хэлбэртэй байх тул харагдах шинжээр нь титэмлэг буюу корона вирус гэж нэрлэжээ. Энэ вирус нь голдуу амьсгалын замын хам шинжит өвчин үүсгэдэг.

Эрдэмтэд хүнд халдварладаг 7 төрлийн корона вирус байдгийг илрүүлээд байна. Үүнээс SARS, MERS (Ойрх Дорнодын амьсгалын замын хам шинжийн вирус) болон шинэ хэлбэрийн корона вирус нь хүнд ноцтой өвчин үүсгэдэг. Корона вирус зөвхөн хүнд халдварлах төдийгүй гахай, үхэр, муур, нохой, булга, тэмээ, сарьсан баавгай, хулгана, зараа зэрэг олон зүйлийн хөхтөн, жигүүртэн амьтанд халдварладаг байна.

2. Шинэ хэлбэрийн корона вирус гэж юу вэ?

Шинэ хэлбэрийн корона вирус гэж урьд өмнө нь хүний биеэс илэрч байгаагүй шинэ вирусийг хэлж байна. 2019 оны 12 сард У хань хотод уушгины үрэвсэлт өвчин үүсгэсэн вирус бол шинэ хэлбэрийн корона вирус юм. ДЭМБ-аас энэ вирусыг 2019-nCoV гэж нэрлэжээ.

3. Шинэ хэлбэрийн корона вирус нь SARS, MERS-ээс ялгаатай юу?

Шинэ хэлбэрийн корона вирус болон SARS, MERS вирус нь гарал үүсэл нэгтэй корона вирусүүд юм. Гэвч генийн хувьслын үр дүнд өөр хоорондоо ялгаатай болж задарсан байна.

4. Ямар хэлбэрийн корона вирус хүнд халдварладаг вэ?

Одоогоор У хань зэрэг хотод уушгины үрэвсэл үүсгэсэн шинэ хэлбэрийн корона вирус болох 2019-nCoV-ээс гадна HCoV-229E, HCoV-OC43, SARS-CoV, HCoV-NL63, HCoV-NKU1, MERS-CoV зэрэг 6 зүйл хүнд халдварладаг корона вирус байдгийг эрдэмтэд илрүүлээд байна.

5. Шинэ хэлбэрийн корона вирус хүнээс хүнд халдварладаг уу?

Халдварлана. Шинэ хэлбэрийн корона вирус юунаас үүссэн нь тодорхойгүй байгаа ч хүнээс хүнд тархан халдварласан нь тодорхой болоод байна.

6. Шинэ хэлбэрийн коронавирус хэрхэн тархан дэлгэрдэг вэ?

БНХАУ-ын Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт судалгаанд үндэслэвэл шинэ хэлбэрийн корона вирус нь шүлс, цэр зэргийн үсэрхийллээс тархан халдварладаг байна. Мөн ойртож хүрэлцсэнээс үүдэн тархах боломж байж бий. Гэвч агаарт дангаар оршиж агаар дуслын замаар тархан дэлгэрэх бололцоотой эсэхийг харахан тодлоогүй байна.

7. Шинэ хэлбэрийн корона вирус өргөн хэмжээгээр тархах эрсдэлтэй юу?

БНХАУ-ын Халдварт өвчин судлалын үндэсний төвийн тандалт судалгаанаас харахад шинэ хэлбэрийн корона вирус нь зохих хэмжээнд тархах эрсдэлтэй. Хэрвээ сэргийлэх арга хэмжээ авахгүй бол 1 өвчтөн 2-3 хүнд халдаах боломж бий.

8. Шинэ хэлбэрийн корона вирусний эсрэг вакцин бий юу?

Шинэ хэлбэрийн корона вирус нь нэг зүйлийн шинээр илрүүлсэн вирус учраас одоохондоо түүнд тохирох вакцин хараахан гараагүй байна. Шинэ хэлбэрийн корона вируст тохирох вакцин гаргаж авахад тодорхой хугацаа шаардагдана.

9. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас сэргийлэх эм бий юу?

Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас сэргийлэх тусгай эм одоохондоо гараагүй.

10. Шинэ хэлбэрийн корона вирусээр халдварласан уушгины үрэвслийг эмчилж чадах уу?

Одоохондоо шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн өвчнийг тусгайлан эмчлэх арга барил байхгүй боловч шинж тэмдгийн эмчилгээ хийх нь өвчнийг илаарьшуулахад нэмэртэй байна. Мөн өвчтөнд тохирох асаргаа сувилгаа хийж тодорхой үр дүнд хүрч байна.

11. Ойрын хавьтагч гэж хэнийг хэлж байна вэ?

Ойрын хавьтагч гэдэг нь өвчтөнтэй (сэжигтэй буюу нэгэнт оношилогдсон хүн) нэг тээврийн хэрэгсэлд суух, нэг анги танхимд хичээллэх, нэг гэрт амьдрах зэргээр ямар нэгэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авалгүйгээр нэг доор байлцсан хүнийг хэлнэ. Ойрын хавьтагч мөн эсэхийг Халдварт өвчин судлалын газрын тусгай мэргэжилтэн эцсийн шатны асуулга байцаалтаар тогтооно.

12. Халдварт өвчин судлалын газраас ойрын хавьтагчаар тодорхойлсон тохиолдолд ямар арга хэмжээ авбал зохих вэ?

Ойрын хавьтагч гэртээ тусгаарлан сууж, эмч мэргэжилтний зааврын дагуу өөртөө ажиглалт хийнэ. Юуны духанд хүрэлгүй айж сандрахын хэрэггүй. Ажилдаа явах хэрэггүй. Дураараа гадагш гарч болохгүй. Биеийн байдлаа ажиглан шинжих ба тогтсон хугацаанд эмч ирж үзнэ. Тогтсон хугацаанаас өмнө халуурах, ханиах зэрэг хэвийн бус шинж тэмдэг илэрвэл хариуцсан газрынхаа эмчид үзүүлж, эмчийн заавраар аль тохирох эмнэлэгт очиж оношлуулан эмчлүүлэх хэрэгтэй.

13. Ойрын хавьтагчийг яагаад 14 хоног тусгаарлан ажигладаг вэ?

Ойрын хавьтагчийг тусгаарлан, ажиглагт хийх нь вирусний тархалтаас сэргийлэх, тархалт дэлгэрэлтийг зогсоох, ард олны эрүүл мэнд аюулгүй байдлыг хангах үүднээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ юм. Одоогийн байдлаар шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвсэлт өвчин нь өвчний вирустэй ойртсоноос хамгийн удаандаа 14 хоногийн хугацаанд илэрч байгаа тул ойрын хавьтагчдад 14 хоногийн ажиглалт хийнэ. 14 хоногт өвчин үүсэхгүй бол энэ өвчин халдварлаагүй гэж тогтоож байна.

14. Халдварт өвчнийг хэдэн төрөлд хуваадаг вэ? Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвсэлт өвчин аль төрөлд багтах вэ?

"БНХАУ-ын Халдварт өвчнийг сэргийлэн засах хууль"-д халдварлах зэргээр нь нэгдүгээр зэрэг (a), хоёрдугаар зэрэг (b), гуравдугаар зэрэг (c) гэж гурав ангилсан 39 төрлийн халдварт өвчин байна гэж заажээ. Үүнээс нэгдүгээр (a) зэргийн халдварт өвчин нь халдварлах шинж нь ноцтой, үхэлд хүргэх магадлал өндөр, өргөн хэмжээгээр амархан дэлгэрнэ.

2020 оны 1 сарын 20-ны өдөр Төрийн зөвлөлөөс шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвслийг "БНХАУ-ын

Халдварт өвчнийг сэргийлэн засах хууль"-д заасан хоёрдугаар (b) зэргийн халдварт өвчний тоонд оруулж, нэгдүгээр (a) зэргийн халдварт өвчнөөс сэргийлэн хориглох арга хэмжээ авахыг зөвшөөрчээ.

15. Шинэ хэлбэрийн корона вирусээр халдварласан хүн бүр уушгины үрэвсэлтэй болох уу?

Одоогийн байдлаар шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвслээр өвчилсөн хүмүүст цээжний рентген зургийн шинжилгээ хийхэд тодорхой хэмжээний өөрчлөлт буюу уушгины үрэвслийн шинж хүн бүрд их бага харилцан адилгүй хэмжээгээр илэрсэн байна.

16. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар авсан өвчтөн эмнэлэгт очиж үзүүлэхдээ ямар арга хэмжээ авбал зохих вэ?

Өвчтөн эмнэлэгт очихдоо нэг удаагийн амны хаалт заавал зүүх шаардлагатай. Өөрийн аялж зорчсон газрууд, ойрын харилцсан хүмүүс, өвчний явц зэргээ эмчид тодорхой хэлж өгч, өвчнийг нарийн зөв оношлоход туслах хэрэгтэй.

ӨВЧНИЙ ИЛРЭЛ, ШИНЖ ТЭМДЭГ

1. Корона вирусийн халдвар авсан бол ямар шинж тэмдэг илрэх вэ?

Корона вирусийн халдвар авсан хүмүүст өвчний хүнд хөнгөнөөсөө хамаарч харилцан адилгүй шинж тэмдэг илэрнэ. Ихэнх тохиолдолд халуурах, ханиах, амьсгал давчдах, амьсгал давчдах шинж илэрдэг. Нэлээд хүндээр өвчилсөн бол халдварлал нь уушгины үрэвсэл, хүнд цочмог амьсгалын хам шинж, бөөрний дутагдал үүсгэж, үхэлд хүргэх аюултай.

Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвсэлт өвчний шинж тэмдэг нь ихэвчлэн халуурах, ядарч сульдах, хий ханиалгах шинжтэй байна. Хамар битүүрэх, нус гоожих зэрэг дээд амьсгалын замын шинж харьцангуй цөөн илэрч байна. Өвчилсөн хүмүүсийн 50 хувьд нь нэг долоо хоног орчмын дараа амьсгал цухалдах хам шинж илэрч байна. Онцгой хүнд тохиолдолд маш хурдан хугацаанд түргэн чанартай амьсгал цухалдах хам шинж илэрч шок, хордлогонд орж, үхэлд хүргэж байна. Зарим тохиолдолд өвчин үүсэх үеийн шинж нь хөнгөн бөгөөд халуурахгүй ч байж болно.

2. Халуурах, ядрах, хий ханиалгах шинж тэмдэг илэрсэн бол шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар авсан гэж ойлгож болох уу?

Олон тооны амьсгалын замын өвчин бүгд халуурах, ядарч сульдах, хий ханиалгах шинж тэмдгээр илэрдэг. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар авсан эсэхийг мэргэжлийн эмч өвчтөний өвчлөхөөс өмнөх үеийн байдал, сэжигтэй өвчтөнтэй ойр харилцаж байсан эсэх, шинжилгээний үр дүн зэргийг үндэслэж, хам магадлалт хийж тогтооно. Иймээс шинэ хэлбэрийн корона вирусээр халдварлагдсан сэжигтэй шинж тэмдэг илэрвэл айн сандрах хэрэггүй. Харин урьдчилан сэргийлэх арга хэмжээ сайтар авч, даруй эмнэлэгт үзүүлэх шаардлагатай.

3. Ямар шинж тэмдэг илэрвэл эмчид хандах шаардлагатай вэ?

Халуурах, сульдах, булчин болон цээжээр хөндүүрлэж өвдөх, ханиах, амьсгал цухалдах шинж илэрвэл даруйхан эмнэлэгт очиж үзүүлэх хэрэгтэй. Мөн өвчний шинж тэмдэг илрэхээс 14 хоногийн доторх аялал, зорчсон газар орон, ойр харилцаанд орсон тухайгаа нарийн тоочиж, оношилгоогоо тодорхой болоход туслах үүрэгтэй.

4. Халуурах, ханиах шинж тэмдэгтэй өвчтөнд эмнэлэг, эмчийн зүгээс ямар эмчилгээ хийж байна вэ? Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвслийг хэрхэн оношилж байгаа вэ?

Халуурах, ханиах шинж тэмдэг илэрсэн өвчтөнд эмнэлгийн байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа эмчилгээний явц нь өвчтөн эмнэлэгт ирж үзүүлэхдээ эхлээд урьдчилан оношлох газарт сувилагчид биеийн температураа үзүүлнэ. Хэрвээ халуурах, ханиалгах шинж илэрсэн бол өвчтөнд амны хаалт яаралтай зүүлгээд, юунаас болж халуурсныг оношлохоор амбулаторид аваачна. Тус амбулаторийн эмч нар өвчтөний өгсөн мэдүүлэгт үндэслэж, асуулга шинжилгээ хийх бөгөөд ингэхдээ өвчний шинж илрэхээс өмнөх 14 хоногт халдварт өвчин гарсан газар оронд очсон эсэх, сэжигтэй өвчтөнтэй ойр харилцаанд орсон эсэхийг асуудаг. Ингээд өвчтөнд илэрсэн шинж тэмдэг нь шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвсэлт өвчинтэй төстэй шинж тэмдэгтэй байхын зэрэгцээ өвчтөн халдварт өвчин гарсан газар орноор зорчсон юм уу эсвэл сэжигтэй өвчтөнтэй ойр харилцаанд орсон байвал даруй эмнэлэгт хэвтүүлж, тусгаарлан эмчилдэг. Бас амны хөндийн арчдас, цэр, шүлс зэргийг Халдварт өвчин судлалын төв юм уу харьяалах эмнэлгийн байгууллагын шинжилгээний тасаг руу явуулж, шинэ хэлбэрийн корона вирус халдварласан эсэх лабораторийн шинжилгээ хийнэ. Шинжилгээний дүн (+) гэж гарвал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвсэл гэж оношилж байна.

5. Танд шинэ хэлбэрийн корона вирус халдварласан байж болзошгүй шинж тэмдэг илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?

Та өөрийгөө шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар авсан байж болзошгүй гэж сэжиглэвэл ажил сургуульдаа явалгүй, харьяалагдах өрхийн эмнэлэг юм уу ойр хавийнхаа эмнэлэгт очиж үзүүлэх хэрэгтэй. Хэрвээ халдварт өвчин гарсан газар оронд зорчсон бол эмчид заавал хэлээрэй. Халдвар авсан үеэсээ хойш ойр харилцаанд орсон хүмүүсээ ч эмчид хэлж, эмчийн асуулга шинжилгээнд туслах хэрэгтэй. Үүний зэрэгцээ өрөө тасалгаандаа агаар оруулж, ариутгал цэвэрлэгээ хийж, гэртээ байсан ч амны хаалт зүүн, гэрийнхэнтэйгээ хэт ойр харилцахаас зайлсхийх нь зүйтэй. Хувийн ариун цэврийг сайтар сахиж, тухай бүрд гараа угааж байгаарай.

6. Таны ойр хавийн хүмүүст шинэ хэлбэрийн корона вирус халдварласан байж болзошгүй шинж тэмдэг илэрвэл ямар арга хэмжээ авах вэ?

Таны ойр хавийн хүмүүст шинэ хэлбэрийн корона вирус халдварласан байж магадгүй гэсэн сэжигтэй шинж илэрвэл юуны түрүүнд амны хаалт зүүн, тэдэнтэй хэт ойртож харилцахаас зайлсхийгээрэй. Мөн тэднийг амны хаалт зүүн, эмнэлэгт очиж үзүүлэхийг санал болгоорой.

7. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалын шинж нь SARS, томуу, ханиаднаас ялгаатай юу?

Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлал нь ихэвчлэн халуурах, сульдаж ядрах, хий ханиалгах шинжээр илэрч байгаа бөгөөд цаашлаад уушгины хурц үрэвсэл үүсгэж байна. Өвчлөл гарсан эхний үед зарим өвчтөнд халуурах шинж тэмдэг илрэхгүй, харин зөвхөн бие загзайх зэрэг амьсгалын замын халдварлалын шинж илэрч байгаа ч СТ зураг авхуулж байж уушги үрэвссэн нь оношлогдож байсныг ч онцгойлон анхаарууштай. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн хүнд өвчтөний өвчний шинж нь SARS-ынхтай төстэй.

Томуу, томуу төст өвчин нь халуурах, ханиах, хоолой өвдөх, булчин хөндүүрлэх зэрэг шинж тэмдгээр илэрдэг. Цөөн тохиолдолд хүндэрч, уушгины үрэвсэл үүсгэх эрсдэлтэй боловч тэр бүр ийм зүйл тохиолддоггүй.

Ханиад хямраа нь хамар битүүрэх, нус гоожих зэрэг шинжээр илдэрдэг. Ихэвчлэн өвчлөлийн хэлбэр нь хөнгөн, ердийн нөхцөлд уушгины үрэвсэлт өвчин үүсгэдэггүй.

8. Ямар хүмүүст шинэ хэлбэрийн корона вирус амархан халдварлаж байна вэ?

Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас үүссэн уушгины үрэвсэлт өвчин нь шинэ гарсан өвчин учраас энэ өвчнийг эсэргүүцэх биеийн дархлаа хэнд ч тогтоогүй байж болно. Тандалт судалгаанаас харвал ахмад настан, залуучууд, хүүхэд гээд бүх насны хүмүүст энэ вирус халдварлаж болзошгүй бөгөөд, ахмад настай хүмүүс харьцангуй олноор өвчилсөн байна.

9. Шинэ хэлбэрийн корона вирусээр халдварлагдсан ямар хүмүүс амархан хүндэрдэг вэ?

Ахмад настан, жирэмсэн эмэгтэйчүүд зэрэг өвчин эсэргүүцэх чадвар султай хүмүүс, мөн элэгний ерөнхий үйл ажиллагаа муу, бөөрний үрэвсэлтэй хүмүүс шинэ хэлбэрийн корона вирусийн халдварт өртвөл нэлээн хүнд тусаж, өвчин даамжрах явц хурдан байна.

Өвчин эсэргүүцэх чадвар, биеийн дархлаа сайтай хүмүүст ч шинэ хэлбэрийн корона вирусийн халдвар тусвал вирусний урвалд орох байдлаас шалтгаалан түргэн чанартай амьсгал давхцах хам шинж илрэх тул онцгойлон анхаарах шаардлагатай.

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

1. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас хэрхэн сэргийлэх вэ?

Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас урьдчилан сэргийлэхийн тулд:

а/ Халдварт өвчин дэлгэрсэн газар оронд зорчихоос зайлсхийх

б/ Олон хүн цугларсан газарт очихоос зайлсхийх. Агаарын солилцоо муутай заал танхимд нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцохоос зайлсхийх. Ялангуяа ахмад настан, хүүхэд болон өвчин эсэргүүцэх чадвар-биеийн дархлаа султай хүмүүс дээр дурдсан газар очихгүй байх хэрэгтэй. Гадагш гарахдаа заавал амны хаалт зүүж байх.

в/ Салхивчаа нээж, агаар салхи оруулж байх. Өдөр бүр гэр, албан тасалгаандаа агаар салхи оруулж, агаарын солилцоог сайжруулж байх нь амьсгалын замын өвчний халдварлалаас сэргийлэх сайн талтай.

г/ Хувийн ариун цэврийг чандлан сахих. Саван юм уу цэвэр усаар гараа 20 секундээс багагүй хугацаагаар нямбай угаах хэрэгтэй. Найтаах, ханиах үедээ цэвэр салфетикаар ам хамраа таглах юм уу эсвэл тохойгоороо халхалж шүлс, нус, цэр үсрэхээс болгоомжлох хэрэгтэй. Гарын алгаараа ам хамраа таглаж болохгүй.

д/ Байнга биеийн байдлаа хянаж, халуурах шинж тэмдэг илэрвэл эмчид үзүүлэх. Хэрвээ удаан хугацаанд халуун буурахгүй, эсвэл өндөр халуурч, ханиалгаж, амьсгал давхцах зэрэг амьсгалын замын халдварлалын шинж тэмдэг илэрвэл яаралтай эмнэлэгт үзүүлэх шаардлагатай.

2. Ойрын хугацаанд халдварт өвчин дэлгэрсэн газар орноор зорчсон бол ямар арга хэмжээ авбал зохих вэ?

Ойрын хугацаанд халдварт өвчин дэлгэрсэн У хань зэрэг газар орноор зорчсон бол өөрийгөө болон ойр орчныхоо хүмүүсийн биеийн байдалд онцгойлон анхаарч, аль болох олон нийтийн үйлчилгээний газраар үйлчлүүлэхгүй, хүн олноор цугларсан газраар очихгүй байхыг хичээгээрэй. Хэрвээ халуурах, сульдах, хий ханиалгах, булчин хөндүүлж өвдөх, амьсгал давчдах шинж илэрвэл эмнэлэгт хэрэглэдэг нэг удаагийн маск зүүж, яаралтай эмнэлэгт үзүүлэх хэрэгтэй. Үзүүлэхдээ

халдварт өвчин дэлгэрсэн газар орноор зорчсон тухайгаа эмчид тодорхой хэлж тэмдэглүүлэх шаардлагатай.

3. Ханиах, найтаах үедээ яах ёстой вэ?

Өвчтөн ханиалгах, найтаалгах үед өвчний вирус агуулж буй шүлс цэр ойролцоогоор эргэн тойрон 2 метр орчим зайд үсэрхийлж, агаарт тархдаг тул ойр орчинд нь байгаа бусад хүн хэрвээ тэрхүү үсэрхийллээр амьсгалж дотогш оруулбал вирусийн халдвар тусах онц аюултай. Иймээс ханиаж найтаах үедээ:

а/ Ханиаж, найтаах үед цэвэр хуурай салфетикаар юм уу тохойгоороо /гарын алгаар биш/ ам хамраа халхлах

б/ Ханиах, найтаах үед хэрэглэсэн салфетикаа тагтай хогийн саванд хийх

в/ Ханиаж найтаасны дараа гараа савандаж угаах юм уу зориулалтын гар ариутгагчаар ариутгах хэрэгтэй.

4. Шинэ хэлбэрийн корона вирусээс сэргийлэхийн тулд хэрхэн ариутгал цэвэрлэгээ хийх вэ?

Шинэ хэлбэрийн корона вирус халуунд тэсвэргүй. Целсийн 56 градуст 30 минут болоход вирус устана. Хлор агуулсан ариутгагч бодис, спирт, йодын төрлийн ариутгах бодис энэ вирусыг тодорхой хугацаанд устгаж чадна.

Арьсыг ариутгахад 75%-ийн спирт, йодын уусмал хэрэглэх бөгөөд бусад салслаг бүрхэвчийг ариутгах тусгай ариутгалын бодисыг хэрэглэнэ. Гэр, өрөө тасалгаагаа ариутгахад хлорамины уусмалыг зөвшөөрөгдсөн хэмжээгээр шингэлж (юуг ариутгахаас хамааран 1 литр тутамд 200-500 миллиграмм) найруулан арчих буюу дэвтээж ариутгана. Халуунд дацтай эд бодисыг 15 минут орчим чанаж ариутгана.

5. Амны хаалтыг хэрхэн сонгох вэ?

Амны хаалт зүүх нь амьсгалын замын халдварлалаас сэргийлэх хамгийн шалгарсан арга юм. Одоогийн байдлаар эмийн сан, дэлгүүрүүдээр ихэвчлэн эмнэлэгт хэрэглэдэг нэг удаагийн амны хаалт, эмнэлэгт хэрэглэдэг сэргийлэн хамгаалах (тухайлбал N95) амны хаалт болон энгийн нэг удаагийн амны хаалт худалдаалж байна. Үүнээс гадна даавуу маарал болон бусад материалаар хийсэн амны хаалт ч байна.

Ердийн нөхцөлд эмнэлэгт хэрэглэдэг нэг удаагийн амны хаалт зүүхэд вирусийн халдварлалаас хангалттай сэргийлж чадна. Мэдээж эмнэлэгт хэрэглэдэг сэргийлэн хамгаалах N95 амны хаалт хэрэглэх нь сэргийлэх үр дүн харьцангуй илүү. Гэвч түүний агаар нэвтрүүлэх чанар хангалтгүй байдаг тул удаан хугацаанд зүүхэд тохиромжгүй талтайг анхаарууштай.

6. Амны хаалтыг хэрхэн зөв зүүх вэ?

Амны хаалтыг зүүхдээ нугалж байгаа хэсгийг нь гүйцэд дэлгээд, ам, хамар, эрүүгээ бүгдийг халхалсны дараа хамрын самсааны дээд хэсгээр чанга хавчиж, амны хаалт болон хацар нүүрний хэсгийг сайтар наалдуулна.

Амны хаалтаа зүүхээс өмнө гараа сайтар угаах хэрэгтэй. Амны хаалтны дотор талд гараар хүргэж бохирдуулахаас болгоомжлох хэрэгтэй. Амны хаалтны дотор, гадар талыг тодорхой ялгах шаардлагатай. Гүн өнгөтэй нь гадар тал, цайвар өнгөтэй нь дотор тал болно. Зүүхдээ дотор талыг нь дотогш хандуулж ам хамартайгаа наалдуулна. Гүн өнгөтэй талыг нь гадагш хандуулж, хамрыг хавчих зориулалттай төмөрлөг ширхэгтэй талыг нь дээд тал болгоно.

Амны хаалтыг тогтмол хугацаанд солино. Дотор гадар, дээд доод талаар нь хольж зүүж болохгүй, ялангуяа гадар дотор талыг сольж зүүж хэрхэвч болохгүй.

7. Гараа хэрхэн зөв угаах вэ?

Хоол идэхээс өмнө, бие зассаны дараа, гаднаас орж ирсний дараа, хог хаягдал зүйл барьсан бол, амьтан жигүүртэнд хүрсэн бол заавал гараа угаах хэрэгтэй. Угаахдаа гартаа саван түрхэж, усаар /үе шаттай/ угаана. Угаах хугацаа 20 секундээс урт байх хэрэгтэй. Гар угаахдаа гарын алга-гарын ар -хуруун салаа- хуруу-эрхий хуруу-хумс- бугуй гэх дарааллыг баримталж угаана.

а/ Гарын алга: Хоёр гарын алгаа хавсруулж, харилцан үрж угаана.

б/ Гарын ар: Нэг гарын алгаараа нөгөө гарын ар талыг үрж, хоёр гараа солбицуулан ээлжилж угаана

в/ Хуруун салаа: Хоёр гарын алгаа хавсруулан арван хуруугаа солбицуулан хурууны завсраа үрж угаана.

г/ Хуруу: Арван хуруугаа дотогш хагас нугалж, хоёр гараа харилцан солбицуулан ээлжилж үрж угаана.

д/ Эрхий хуруу: Нэг гараараа нөгөө гарынхаа эрхий хурууг атгаж, солбицуулан үрж угаана.

е/ Хумс, хурууны үзүүр: Хумсаа гарын алгандаа үрж угаана.

ё/ Бугуй: Хоёр гарын бугуйгаа ээлжилж угаана.

8. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвараас сэргийлэхдээ идээ ундандаа хэрхэн анхаарах вэ?

"БНХАУ-ын суугуул иргэдийн идээ ундааны зөвлөмж"-ийн дагуу өдөр тутмын хоолны бүтцийг чухалчлан, шим тэжээлийн зохистой байдалд анхаарч, мах, гурил, будаа, жимс, ногооны харьцлыг тэнцүүлэн, витаминьг хоолоор нөхвөрлөн, ус зохих хэмжээгээр уух хэрэгтэй.

Онцгойлон, идээ ундаагаар шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалыг устгах тухайтай элдэв зүйлийн цуу яриаг туршиж хугацаа алдаж болохгүй, хэрвээ сэжигтэй шинж илэрвэл даруй сэргийлэх арга хэмжээ авч, эмнэлэгт очиж үзүүлэх хэрэгтэй.

9. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас гэр зуураа хэрхэн сэргийлэх вэ?

Гэр, өрөө тасалгаандаа агаар салхи оруулж байх шаардлагатай. Долоо хоног тутамд нэгээс доошгүй удаа их цэвэрлэгээ хийхийг хичээх хэрэгтэй. Хэрвээ гэрийн тавилга, цонхны тавцан, шалны гадаргад шүлс, цэр, нус, бөөлжис, ялгадас болсон бол ус сайн шингээдэг даавуугаар ил хогийг арчиж аваад, ариутгалын бодисоор бохирдсон газар болон орчин тойрныг ариутгах хэрэгтэй.

10. Шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас гадагш гарахдаа хэрхэн сэргийлэх вэ?

Гадагш гарахдаа юуны өмнө өөрийн биеийн байдлаа ажиглах хэрэгтэй. Сүүлийн үед халуурах, ханиалгах шинж тэмдэг илэрсэн бол гарах ажлаа хойшлуулж, эхлээд эмнэлэгт үзүүлэх хэрэгтэй.

Мөн У хань зэрэг өвчин дэлгэрсэн газар орон руу явахаас зайлсхийх хэрэгтэй. Бусад газраар явахдаа ч амны хаалт зүүж, найтааж ханиах үедээ салфетик зэргийг хэрэглэж, гараараа нүүр нүдээ нухалж барихаас зайлсхийн, орцны хаалга, шатны бариул зэрэг дундын өмчид хүрсний дараа тухай бүрд гараа сайтар угааж хэвшээрэй.

11. Ахмад настан, бага насны хүүхэд шинэ хэлбэрийн корона вирусийн халдвараас хэрхэн сэргийлэх вэ?

Энэ удаа дэлгэрсэн шинэ хэлбэрийн корона вирусээр ахмад настан харьцангуй илүү өвчилж байгаа тул ахмад настангууд тодорхой хугацаанд нийтийг хамарсан цуглаан, олон нийтийн үйл ажиллагаанд аль болох очихгүй байж, гадагш гарахдаа эрхбиш амны хаалт зүүж, орж ирээд гараа сайтар угааж хэвшээрэй.

Хүүхэд нялхас харьцангуй цөөн өвчилсөн тоон мэдээ байгаа боловч хүүхдийн халдвар эсэргүүцэх ерөнхий чадвар сул байдаг тул заавал урьдчилан сэргийлэх шаардлагатай юм. Иймд аль болох гадагш гаргахгүй гэрт нь байлгаж, зайлшгүй гарах тохиолдолд амны хаалт зүүлгэж, гарыг байнга угааж байгаарай. Бага насны хүүхдийг, ялангуяа нярай нялх хүүхдийг үнсэж, үнгэх зуршлаа хязгаарлаарай.

12. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, амьтны дэлгүүрээр үйлчлүүлэхдээ шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас хэрхэн сэргийлж явах вэ?

Гэрийн тэжээвэр амьтан болон хээрийн амьтны дэлгүүр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн худалдаалдаг зах дэлгүүрээр үйлчлүүлэхдээ заавал амны хаалт зүүсэн байх шаардлагатай. Амьтантай шууд гараар хүрэлцэх, өвчтэй мал амьтныг муулах, үхсэн мал амьтны зэм сэгт хүрэх, зэрлэг амьтны мах идэхээс татгалзах хэрэгтэй.

13. Найз нөхөд, байгууллага хамт олныг хамарсан найр наадамд очихдоо өвчлөлөөс хэрхэн сэргийлэх вэ?

Хэрвээ танд халуурах, ханиалгах, хоолой өвдөх зэрэг тааламжгүй шинж тэмдэг илэрч байвал найр наадамд очих хэрэггүй. Өвчин тархаж байгаа хугацаанд аль болох найр наадмыг багасгах нь өвчин халдварлах замыг хааж байгаа хэрэг юм. Заавал очих шаардлагатай бол амны хаалт зүүж, вирусийн тархалтыг хязгаарлаарай. Олон хүн цуглуулах зайлшгүй шаардлагатай нөхцөлд аль болох агаар салхи сайн нэвтрэх өрөө тасалгааг сонгоорой.

14. Олон нийтийг хамарсан уулзалт цуглаанд очихдоо өвчлөлөөс хэрхэн сэргийлэх вэ?

Халдварт өвчин дэлгэрээд байгаа энэ үед олон нийтийг хамарсан уулзалт цуглаанд оролцохгүй байх нь өвчилсөн хүмүүстэй уулзах тохиолдлыг багасгана. Зайлшгүй оролцох шаардлагатай бол амны заалт зүүж очих нь өвчин үүсгэгч вирусийн халдварлал тусах эрсдэлийг бууруулна. Иймээс тохирох амны хаалтыг сонгож, зөв зүүх нь өвчлөлөөс сэргийлэх чухал алхам юм.

БУРУУ ОЙЛГОЛТ

1. Өрөө тасалгаагаа хоолны цуугаар ариутгавал шинэ хэлбэрийн корона вирусийг устгаж чадах уу?

Чадахгүй. Хүнсэнд хэрэглэдэг цууны хүчлийн агууламж тийм ч өндөр биш байдаг тул ариутгах чадалгүй, харин ч хүний нүдний салст болон амьсгалын замын эрхтэнийг цочроох эрсдэлтэй.

2. Вирусний эсрэг эм болох phosphoric acid, oseltamivir зэргийг уувал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?

Хэдийгээр phosphoric acid (磷酸), oseltamivir (奥司他韦) зэрэг нь вирусний эсрэг эм боловч шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалаас сэргийлж чадах эм мөн эсэхийг одоогийн байдлаар тогтоож чадаагүй.

3. Антибиотек уувал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?

Чадахгүй. Шинэ хэлбэрийн корона вирусээр халдварлагдсан уушгины үрэвслийн өвчин үүсгэгч нь нян биш вирус юм. Харин антибиотек нь нянгийн эсрэг эм бөгөөд бактерийг дарах ерөндөг болдог. Иймээс антибиотекийг эмчийн заалтгүй буруу хэрэглэвэл эсрэгээрээ өвчин үүсгэгчийн эмд дасан зохицох чанарыг нэмэгдүүлж болзошгүй.

4. Витамин С уувал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?

Чадахгүй. Витамин С нь бие махбодын хэвийн өвчин эсэргүүцэх чадварыг баталж чадах ч, өвчин эсэргүүцэх чадварыг нэмэгдүүлж чадахгүй бөгөөд ялангуяа вирусийг эсэргүүцэх нөлөө үзүүлдэггүй, зөвхөн өвчнийг эмчлэх явцад өвчний эдгэрэлтийг хурдасгахад туслах нөлөө үзүүлдэг.

5. Амны хаалтыг давхарлан зүүвэл шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж чадах уу?

Амны хаалтыг давхарлан зүүх хэрэггүй, ганцыг зүүхэд хангалттай. Амны хаалтыг гурав дөрвөөр нь давхарлан зүүх нь агаар чөлөөтэй нэвтрэхэд саад болж, эсрэгээрээ сэргийлэн хамгаалах үр дүнгүй болно. Үүний зэрэгцээ N95 буюу эмнэлэгт өвчтөнтэй шууд харьцах үед хэрэглэдэг амны хаалтыг заавал сонгон хэрэглэх гэсний шаардлагагүй, эмнэлэгт хэрэглэдэг нэг удаагийн энгийн амны хаалт хэрэглэсэн ч шүлс цэр үсрэн халдварлахаас сэргийлж чадна.

6. Ханиад, томуугийн вирусээс сэргийлж ханиад томууны вакцин тариулдаг. Энэ вакциныг тариулбал шинэ хэлбэрийн корона вирусийн халдварлалтаас сэргийлж, вирусээр халдварласан ч гэсэн өвчин хүндрэхгүй байж чадах уу?

Томуугийн вакцин нь томуу томуу төст өвчин тусахаас сэргийлж чадахаас биш шинэ хэлбэрийн корона вирусээс сэргийлж чадахгүй. Хэдийгээр томуугийн вакцин тариулсан байсан ч шинэ хэлбэрийн корона вирусээр халдварлагдах магадлал хэвээр бөгөөд өвчлөл хүнд маягаар ч илэрч болзошгүй.

Орчуулсан Бярган Д.Наранцэцэг

2020.01.29

新型冠状病毒感染防护
Xinxing Guanzhuangbingdu Ganran Fanghu

Шинэ хэлбэрийн корона вирусийн халдвараас сэргийлэх нь
номын найруулах комисс

Эрхлэн найруулагч: Хэ Жиэнь фэн
Сүн Тиэ

Дэд эрхлэн найруулагч: Кан Минь
Ян Фэнь

Найруулагчид:
Жуан Яа ли
Ян Фэнь
Хэ Жиэнь фэн
Сүн Тиэ
Чэнь Шю гуан
Луо Минь
Кан Минь
Фэн Шинь
Жиан Жин
Тань Шяо хуа

新型

主编单位 广东省疾病预防控制中心


主 编 何剑峰 宋 铁

冠状病毒感染 防护

什么是新型冠状病毒

人感染冠状病毒后会有什么症状

如何预防新型冠状病毒感染



SPM 南方出版传媒

广东科技出版社 | 全国优秀出版社

图书在版编目(CIP)数据

新型冠状病毒感染防护 / 何剑峰, 宋铁主编. —广州: 广东科技出版社, 2020.1

ISBN 978-7-5359-7419-8

I. ①新… II. ①何… ②宋… III. ①日冕形病毒—病毒病—预防(卫生) IV. ①R563.101

中国版本图书馆CIP数据核字(2020)第019183号

新型冠状病毒感染防护

Xinxing Guanzhuangbingdu Ganran Fanghu

项目总统筹: 应中伟

出版人: 朱文清

责任编辑: 吕健 曾永琳 黎青青 马霄行 邹荣

封面设计: 林少娟 李晶

版面设计: 友间文化

责任校对: 陈静 李云柯

责任印制: 彭海波

出版发行: 广东科技出版社

(广州市环市东路水荫路11号 邮政编码: 510075)

销售热线: 020-37592148 / 37607413

<http://www.gdstp.com.cn>

E-mail: gdkjzbb@gdstp.com.cn (编务室)

经 销: 广东新华发行集团股份有限公司

印 刷: 广东新华印刷有限公司

(广东省佛山市南海区盐步河东中心路 邮政编码: 528247)

规 格: 889mm × 1 194mm 1/32 印张2 字数40千

版 次: 2020年1月第1版

2020年1月第1次印刷

定 价: 8.00元

如发现因印装质量问题影响阅读, 请与广东科技出版社印制室联系调换(电话: 020-37607272)。